

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС 2022 ОНД ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс нь оны эхний нэгдүгээр улиралд Цагдаагийн албаны тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөө, цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлж, улсын хэмжээнд зохион байгуулж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжил, арга зүй, удирдлагаар ханган, үр дүнг тооцож ажиллалаа.

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл”, 21-нд “Зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл”, 27-ны өдөр “Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл”-ийн хуралд тус тус оролцсон. Хурлаар 2021 онд хийсэн ажлаа тайлагнаж, 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн баталсан.

Мөн “Зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл”-ийг татан буулгаж, Зам тээврийн хөгжлийн яамны дэргэдэх “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөл”-тэй нэгтгэх шийдвэр гарсан.

Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн хууль эрх зүйн орчин болон ажлын албаны үйл ажиллагааны талаар гишүүдэд мэдээлэл өгөх, 2021 оны үйл ажиллагааны тайлан, 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцэх, 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулагдсан хуралдаанд оролцсон.

Цагдаагийн ерөнхий газар, Монголын залуучуудын холбооны хамтарсан уулзалтыг энэ оны 04 дүгээр сарын 01-ний өдөр ЦЕГ-ын Хурлын танхимд зохион байгуулж согтуугаар үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр соён гэгээрүүлэх ажлууд хамтран зохион явуулах, цагдаагийн алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нэр хүндийг нийгэмд дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулах, залуусын эрүүл мэнд, бие бялдарыг дэмжих гэсэн үндсэн 3 чиглэлээр “Хамтран ажиллах санамж бичиг” байгуулсан.

Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс Хэнтий аймгийн Чингис хотноо зохион байгуулсан “Хүрээлэн байгаа орчинд ээлтэй аялал жуулчлал ба гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь-2022” улсын зөвлөгөөнд оролцсон.

Хоёр. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Сар шинэ-2022”, “Тэнэмэл-1,2,3”, “Зөвийг зөвлөө”, “Цахим соёл”, “Мал мах-Хяналт”, “Шийдвэрлэт” “Carback”, “Арлын дугаар”, “Ломбард хяналт”, “Халаас”, “РС-бүртгэл”, “Халхавч”, “Эрэлч нохой-2022”, “Илрүүлэлт-Оргодол-2022”, “Тэрбум мод” аяны хүрээнд “Байгалиа бүтээе-I.II”, “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ”, “Залилан”, “Хичээл эхэллээ”, “Unsend”, “Намайг алгас” зэрэг тусгай арга хэмжээ 12, хэсэгчилсэн 1755, нийт 1767 арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан байна.

Хулгайлах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Сар шинэ 2022” ерөнхий арга хэмжээ 01 дүгээр сарын 21-нээс 02 дугаар сарын 06-ны өдрийн хугацаанд зохион байгуулж, улсын хэмжээнд нийт 793 лед дэлгэц, 286 хулдаасан самбарт сэрэмжлүүлэг мэдээлэл байршуулж, 65390 зурагт хуудас, санамж тарааж, гудамж талбай, зах худалдааны төв орчмоор 2953 удаа чанга яригчаар сэрэмжлүүлэг, мэдээлэл өгч, 155 зөрчил илрүүлж, 87 хуулийн этгээд, 68 хүнд 96.500.000 төгрөгийн торгууль ногдуулж ажилласан байна.

Түүнчлэн нийслэлийн хэмжээнд “Дахин сэрэмжилье-Дахин шалгая 3” тусгай арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжилт, явц байдалтай дүүргүүдийн нутаг дэвсгэрт биечлэн очиж танилцан, чиглэл өгч, үйл ажиллагааг идэвхжүүлэн ажилласан.

Сар шинийн баяр болохтой холбогдуулан гудамж талбай, олон нийтийн газарт гар дээрээс шинэ мөнгөн тэмдэгийг худалдаалж байгаа иргэдэд хяналт тавьж хуурамч мөнгөн тэмдэгт үйлдэх, ашиглах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор энэ оны 01 дүгээр сарын 24-ний өдрөөс 02 дугаар сарын 11-ний өдрийн хооронд ЭЦА-ны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс улсын хэмжээнд зохион явуулж буй “Хуурамч мөнгө” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд 5000 болон 20000 төгрөгийн дэвсгэртийг таних тэмдгийг харуулсан зурагт хуудас бэлдэж, цахим хэлбэрээр иргэд, олон нийтэд түгээсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хорих ангиудаас ялын хугацаа дуусч суллагдсан 15 хүнийг бүртгэл судалгаанд авч, оршин суух хаягийн дагуу материалыг шилжүүлсэн.

Нийслэл хотод гэр оронгүй тэнэмэл байдлаар амьдардаг иргэдийг болзошгүй эрсдэлээс хамгаалах, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах, гэмт хэрэг зөрчилд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх нийгэмшүүлэх зорилгоор “Тэнэмэл” тусгай арга хэмжээг Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Нийгмийн хамгааллын тусгай төв, Нийслэлийн хөдөлмөр халамжийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар болон төрийн бус байгууллагуудтай хамтран энэ оны 02, 03, 11 дүгээр сард нийт 3 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 959 орон сууцны 1052 орц, хонгил, 96 барилга байгууламж, 12 хүнсний зах, худалдааны төв, 125 дулааны худаг, хоёрдогч түүхий эд авах цэгт үзлэг шалгалт хийж, нийт 368 хүнийг олж тогтоон, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулснаас 13 иргэнийг ар гэрт нь, коронавируст халдвар /ковид-19/-ын эерэг хариу гарсан 1 иргэнийг “Энэрэл” эмнэлэгт, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх “Нийгмийн хамгааллын тусгай төв”, “Өлзийт асар”, “Титэм констракшин”, “Дөлгөөн минж”, “Шинэ амьдрал ялагч” зэрэг 5 төрийн болон төрийн бус байгууллагуудад 354 иргэнийг тус тус хүлээлгэн өгчээ.


Мөн Цагдаагийн байгууллага архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр төр захиргааны байгууллагуудтай хамтран “Итгэл” төслийг 2021 оны 09 дүгээр сараас хэрэгжүүлэн архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэдэг зорилтот бүлгийн иргэдийг сайн дурын эмчилгээнд хамруулж эхэлсэн.

Төсөлд хамрагдсан иргэдэд олон улсын арга зүйд суурилсан 28 хоногийн эм, эмчилгээ, сэтгэл заслын хосолсон хөтөлбөрийг боловсруулан, хордлого тайлах эмчилгээ, “Сайн санаа, сайхан сэтгэл” 4С сэтгэл заслын эмчилгээ, бясалгал иог дуун эмчилгээ, гэр бүлийн уулзалт, зөвлөгөө үйлчилгээг цогц байдлаар хүргэж, өнөөдрийн байдлаар 270 хүнийг архинаас гаргасан нь сайн туршлага болж байна

Хууль зүй, дотоод хэргийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Үндэсний дата төв, Харилцаа холбооны зохицуулах хороо, Нийслэлийн мэдээлэл

технологийн газар, үүрэн телефоны Скайтел, Жи мобайл, Юнител зэрэг үндэсний оператор компаний төлөөлөл нийт 15 байгууллагын удирдах ажилтнуудыг оролцуулан 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдөр “Халаасны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулсан.


Хэлэлцүүлгээр гар утасны хулгайн гэмт хэргийн гаралтыг бууруулах, хууль бус зах зээлийг хумих, хяналтад байлгах зорилгоор www.smartdevice.mn буюу ухаалаг гар утасны бүртгэлийн систем санхүүжилтгүйн улмаас зогсонги байдалд орсныг шийдвэрлүүлэх, нийтийн тээврийн автобусны хяналтын камерын 84,2 хувь ажиллагаагүй зэрэг зөрчлийг арилгуулах талаар хэлэлцсэн.



Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, архины зохисгүй хэрэглээг багасгах, тэднийг зөв үйлдэлд уриалах, согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Зөвийг зөвлөө” арга хэмжээг 2022 оны 03 дугаар сарын 03-наас 24-ний өдрийн хооронд улсын хэмжээнд зохион байгуулсан.

Арга хэмжээний хүрээнд нийслэл хотод байрлах 9 их, дээд сургууль, 26 телевиз, радио, сайт, сонин зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, 3 спортын холбоо, 6 төрийн байгууллага, нийт 46 төрийн болон төрийн бус байгууллагын 74600 ажилтан, алба хаагч, 66 олны танил эрхмийг аянд нэгдүүлж, гудамж талбай, аж ахуйн нэгж, байгууллагын гадна талд байрлах 780 лед дэлгэц, 485 томоохон самбарт хулдаасан хэвлэлийг байршуулж, архины хор уршгийг олон нийтэд сурталчилсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2022 оны 05, 10 дугаар саруудад цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас “Байгалиа бүтээе” нөлөөллийн аяныг улсын хэмжээнд зохион байгуулж, Эх дэлхий, байгаль орчноо хайрлан хамгаалж зохицон амьдрах, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилго бүхий шинжлэх ухаан, танин мэдэхүйн чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран 62 видео шторк, 52 зурагт постер, контентуудыг бэлтгэн цахим орчинд байршуулж түгээснийг 223.836 хүн дэмжиж, 128.271 хүн эерэг сэтгэгдэл үлдээж, 1.318.777 хүн бусдад түгээсэн ба давхардсан тоогоор 18.547.100 хүнд хүрсэн байна.



Сурталчилгааны ажлын хүрээнд хийгдсэн контентуудыг орон сууцны 900 лифт, зорилтот мэдээллийг 10 фм радио, хотын төвийн үндсэн 8 самбар, сурталчилгааны 40 самбарт мэдээлэл тус тус байршуулж, цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагаас “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд нийт 72085 ширхэг мод тарьсан үр дүнтэй ажил болсон.

Монгол цэрэг энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Д.Сүхбаатарын талбайд “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэд олон нийтийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх чиглэлээр үйл ажиллагааг сурталчилан иргэдэд хүргэх сэрэмжлүүлэг, гарын авлага материал байршуулж, 3500 гаруй иргэдэд хууль эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан.


Түүнчлэн өдөрлөгийн үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх, Монгол Улсын засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлага, гадаад орнуудаас Монгол Улсад суугаа дипломат байгууллагын төлөөлөгчид, энхийг сахиулагч бэлтгэл генералууд асарт хүрэлцэн ирж, цагдаагийн байгууллагаас зохион байгуулсан ажил, арга хэмжээтэй танилцсан.

Цагдаагийн байгууллагаас Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийт, хүүхэд, багачуудад сурталчлах, үзэсгэлэн, урлаг, соёл, спортын уралдаан, тэмцээн, өдөрлөгийг багтаасан “ХҮҮХЭД ТАНЫГ ХАМГААЛЪЯ” арга хэмжээг энэ оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 01-ний хооронд зохион байгуулахад бусад алба, нэгж, газар хэлтсүүдтэй хамтран ажиллаж дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажилласан. Үүнд:

Ахиллис Монголиа ТББ-тай хамтран тусгай хэрэгцээт болон энгийн 500 гаруй хүүхдийн “Багачуудын хөгжилтэй гүйлтийн тэмцээн”-ийг энэ оны 05 сарын 22-ны өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулахад хамтран ажиллаж, тэмцээнийг цагдаагийн байгууллагаас 64 алба хаагчид дэмжин ажиллаж, аюулгүй байдлыг нь хангах, хүүхдүүдтэй хөтөчөөр хамт гүйж, уралдааныг хөгжөөн дэмжиж урлагийн тоглолт, үзүүлбэрийг бэлтгэн оролцсон.

Түүнчлэн хүүхдийг зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх “5 Хором хүлээ” аяныг Зариг.мн сайттай хамтран зохион байгуулж Нийслэлийн 6 дүүргийн төрийн болон төрийн бус 289 ерөнхий боловсролын сургуулиудад “School police” эцэг эхийн эргүүлийн хантааз 900 гаруй ширхэгийг хүлээлгэн өгч хамтран ажилласан.

“Залилах” гэмт хэрэгт иргэн, хуулийн этгээдийг өртөхөөс урьдчилан сэргийлэх, хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хор уршгийг таниулах зорилгоор энэ оны 06, 09 дүгээр сард 2 удаа урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж иргэн, хуулийн этгээдийг залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр мэдээллийн сайтуудаар нийт 22 сэрэмжлүүлэг нийтлэл нийтлүүлж, нийт 95 сэрэмжүүлэг мэдээлэл, видеог төв, орон нутгийн цагдаагийн байгууллагын цахим орчинд түгээсэн нь давхардсан тоогоор 10.024.438 хүнд хүрсэн.



10.024.438 хүнд хүрсэн.

Уг арга хэмжээний хугацаанд 858 залилах гэмт хэрэг бүртгэгдсэнээс 154 хэрэг буюу 17.9 хувийг шүүхэд шилжүүлж, 191 хэрэг буюу 22.2 хувийг хааж, 605 хэрэг буюу 70.5 хувийг бусад хэрэгт нэгтгэн шийдвэрлэж, энэ төрлийн гэмт хэргийн гаралт 4,7 хувиар буурсан эерэг үр дүн гарсан.

Зам тээврийн осол, хэргийн гаралтыг бууруулах, хөдөлгөөнд оролцогчдын буруу дадал хандлагыг өөрчлөх, зөв үйлдэлд уриалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс 7 дугаар сарын 20-ны өдрийн хүртэлх хугацаанд цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ” нөлөөллийн аяныг улсын хэмжээнд зохион байгуулсан.

Хөдөлгөөнд оролцогчдын буруу дадал хандлагыг өөрчлөх, зөв үйлдэлд уриалах, иргэдэд мэдлэг, мэдээлэл, сэрэмжлүүлэг, ухаарал олгох агуулга бүхий 26 зурагт постер, 13 видео контентийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран бэлтгэж, хэвлэл болон олон нийтийн цахим сүлжээнд байршуулж, контент, мэдээллүүдийг хотын төв болон хүмүүс олноор зорчдог, үйлчлүүлдэг 19 аж ахуйн нэгж, байгууллага, гудамж талбайн 50 гаруй, орон

сууцны лифтний 557 лед дэлгэцээр, хотын төвийн гол 7 уулзварт, зам дагуу 20 сурталчилгааны самбар, хүнсний үйлдвэрийн түгээлтийн болон хот хоорондын хүн тээврийн нийт 23 байгууллагын 238 автобус, тээврийн хэрэгсэлд аяныг сурталчилсан стикер, сурталчилгаа байрлуулж, төв суурин газраас орон нутаг руу зорчиж буй 25600 жолооч, зорчигч нарт хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж явах захидлыг гардуулан өгч, нийт 326 контент, мэдээллийг бэлтгэн, цахим орчинд байршуулсныг давхардсан тоогоор нийт 37.409.603 хүн үзсэн.



Түүнчлэн кабелийн телевизийн сувгуудын сурталчилгааны самбарт “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ” аяны сурталчилгааны баннерыг байршуулж 710.000 өрх, үүрэн телефоны 4 байгууллагаар зорилтот мессеж /зурвас/-ийг 3,275.251 хэрэглэгчийн гар утсанд илгээсэн байна.

Тус нөлөөлийн аян нь Соёлын яамнаас жил бүр зохион байгуулдаг “Мөнгөн мод” наадмаас Зар сурталчилгааны шилдэг бүтээлд нэр дэвшин шалгарсан.

Охид, эмэгтэйчүүдийг хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран “Мөрөөдлийн шүхэр” аяныг 2022 оны 07 дугаар сарын 31-нээс 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд 2 дахь жилдээ зохион явуулсан.



Арга хэмжээний хүрээнд өдөрлөг, хэлэлцүүлэг, сэтгүүлчдийн дунд тэтгэлэгт уралдаан тус бүр 1 удаа зохион байгуулж, 2 төрлийн постер, 1 лайв, ярилцлага, видео бүтээн цахим орчинд түгээлт хийснийг 732.405 хүн үзэж, 195 удаа бусадтай хуваалцсан нь сошиал орчинд нийт 2 сая хандалт авсан.

Түүнчлэн хүн худалдаалах гэмт хэрэг болон бэлгийн мөлжлөг гэж юу болох, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болоход хүргэж болох эрсдэлт хүчин зүйлс, илрэх шинж тэмдэг болон хохирогч болсон тухай мэдээллийн тухай заавар, зөвлөгөө, мэдээллийг агуулсан 3 төрлийн 2000 ширхэг зурагт хуудас, гарын авлага, материалыг бэлтгэн иргэд, олон нийтэд хүргэсэн.

Хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан оюутан, залуусыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэлийн соёл урлагийн газартай хамтран “Хотын соёл ба хариуцлагатай иргэн” сэдэвт сургалтыг 77 их, дээд сургууль болон коллеж, мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвийн 5800 гаруй оюутан, залуучуудыг оролцуулан зохион байгууллаа.



Олон улсын сайн туршлага, дэвшилтэд технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран нийслэл хотын теле камерын тоог нэмэгдүүлж, ашиглалтыг үр дүнтэй болгох “Аюулгүй хот”-ыг бий болгох зорилтын хүрээнд өнөөгийн нийгэм эдийн засгийн нөхцөл байдалд тохируулан камерын хяналттай “Ногоон бүс” төслийг хэсэгчлэн зохион байгуулах ажлын хүрээнд эхний ээлжинд Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо 1-р дөчин мянгатын нутаг дэвсгэрийн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээгээр дүүргийн

хэмжээнд хулгайлах, халаасны хулгайн гэмт хэргийн 31.7 хувь үйлдэгддэг, өдөртөө Улаанбаатар хотын иргэдийн 60 орчим хувь нь зорчин өнгөрдөг, аж ахуй нэгжийн төвлөрөлт, дэд бүтэц зэрэг хүчин зүйлд тулгуурлан сонгон авч теле камерын хяналтад бүрэн оруулах ажлыг амжилттай хэрэгжүүлсэн.

Олон улсад хэрэгжиж буй “Green zone” төсөл нь дэлхийн 3 орон буюу Бүгд Найрамдах Солонгос улсын Сөүл хот, Оросын холбооны улсын Москва хот, Англи улсын Лондон хотуудад амжилттай хэрэгжиж, камерийн хяналтаар нийт гэмт хэргийн 45-47 хувийг илрүүлсэн тэргүүн туршлага байгааг үндэслэн Чингэлтэй дүүргийн 1-р хорооны 19.7 га газрын 61 цэгт 145 камер шинээр байршуулах, түүнд шаардагдах төсөв тооцоонд тулгуурлан төр, хувийн хэвшлийн аж ахуй нэгж байгууллага, иргэдийн хамтын санхүүжилтын дэмжлэгтэйгээр камер суурилуулах ажлыг зохион байгуулсан.



Телехяналтын нэгдсэн төв нь нийтийн эзэмшлийн гудамж, талбайд суурилуулсан камеруудын дүрсийг нэгтгэж харах зорилго бүхий 25 ширхэг ханан дэлгэц бүхий нэг дор 800 ширхэг камерийн дүрсийг хянах стандартын шаардлагад нийцсэн зориулалтын шал, хана, хөргүүр зэргийг цогцоор нь шийдвэрлэсэнээрээ онцлог юм.

Түүнчлэн Улаанбаатар хотод олон улсын жишигт нийцсэн “Ногоон бүс” бүхий хороо анх удаа байгуулагдсан нь иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангасан, тэргүүн туршлага болохуйц ажил болсон.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газартай хамтран иргэд, олон нийтийг согтууруулах ундааны хорт зуршил, буруу хэрэглээнээс татгалзуулах, түүнээс үүдэн гарах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс 12 дугаар сарын 15-ны өдөр хүртэл хугацаанд “Намайг алгас” нөлөөллийн аяныг зохион байгуулж бэлтгэл ажлын хүрээнд аяны брэндиг, стратегийг боловсруулж, олон нийтийн дундах архины өргөн хэрэглээг бууруулах, зохисгүй хэрэглээг бууруулах, зөв хандлага, сонголт, шинэ соёлыг төлөвшүүлэх, дэмжихэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны 28 ажил, арга хэмжээг төлөвлөн, зохион байгуулж үндсэн 142 видео шторк, 36 зурагт постерыг мэргэжлийн байгууллагуудаар бүтээлгэн иргэд, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан.



Бэлтгэсэн видео контент, мэдээ, мэдээллүүдийг төв, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг иргэн, хуулийн этгээдийн 130, худалдаа, үзвэр үйлчилгээний 214, нийт 344 сурталчилгааны лед дэлгэцээр нийтийн орон сууцны 900 лифт, 42 телевиз, 30 фм радиогоор тус тус түгээж, автобусны буудал болон автозам дагуу 143, бусад байршилд 38, нийт 181 мэдээллийн самбарт “Намайг алгас” сурталчилгаа, мэдээллийн постерыг байршуулсан.

Иргэдийг соён гэгээрүүлэх, идэвхжүүлэх зорилгоор уулзалт, өдөрлөг, сургалт, хэлэлцүүлгийг давхардсан тоогоор 609 удаа зохион байгуулж, арга хэмжээний үндсэн агуулгыг таниулсан тараах материалыг 30.000 ширхэг хэвлэн төв, орон нутгийн худалгаа үйлчилгээний газар болон иргэд олноор цугладаг цэгүүдэд тарааж, улсын томоохон их, дээд сургуулийн төлөөлөл 1200 гаруй оюутан,



залуусыг хамруулан энэ оны 11 дүгээр сарын 30-ны өдөр “ЮЖ Арина” цогцолборт зохион байгуулж, хэвлэл, мэдээллийн 23 телевиз, сайтаар иргэд, олон нийтэд түгээсэн.



Хамт олон, найз нөхдийн дундах архидалт, тэмдэглэлт өдрүүдийн архи согтууруулах ундааны хэт их хэрэглээг шүүмжилсэн, буруу үзэгдэл үйл явдлаас залуу үеийг татгалзуулж, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хосууд гэр бүлдээ цаг зарцуулахад уриалсан 2 дууг бүтээн иргэд, олон нийтийн хүртээл болгосон.

Кабелийн телевизийн сурталчилгааны самбарт “Намайг алгас” аяны сурталчилгааны баннерийг байршуулж 400.000 хэрэглэгч айл, өрхөд, үүрэн холбооны 1.475.251 хэрэглэгчийн дуудлагын аянд зохисгүй хэрэглээнээс татгалзах уриалга бүхий шторкийг байршуулах боломжийг бүрдүүлж, хамтран ажилласан.

Ухуулга, нөлөөллийн арга хэмжээний үр дүнд цахим орчинд , 67.060.623 хүнд хүрч, гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй нийт дуудлага мэдээлэл өмнөх сарын мөн үетэй харьцуулахад 1044, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчил гаргасан гэх дуудлага мэдээлэл 337 нэгжээр тус тус буурсан эерэг үзүүлэлт гарсан.

Хулгайлах, хүчиндэх, хар тамхи, залилах, хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэл, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 12 видео шторк, 25 зурагт хуудасыг бэлтгэн иргэд, олон нийтэд хүргэж, иргэдийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор давхардсан тоогоор 18.744 иргэнд 325 удаагийн сургалт, 6 удаагийн хэлэлцүүлэг, 4 удаагийн уулзалт, зөвлөгөөнийг тус тус зохион байгуулж, аймаг, дүүргийн ГХУСАЗСЗ-өөс санхүүжилтийг шийдвэрлүүлж, сэрэмжлүүлэг бүхий 8000 ширхэг гарын авлага, 7500 ширхэг санамж, сэрэмжлүүлгийг бэлтгэн хэвлүүлж иргэд, олон нийтэд тараасан байна.

Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор МҮОНРТ, MN25, SBN, “Амрыг Эрье”, “Сайхан Монгол”, “Алтанговь ТВ”, “Хөсгөлийн ард түмний ТВ”, “АВ” “Саян”, “Дербес”, “Өлзий”, “ТBS”, “Төв ТВ” зэрэг төв, орон нутгийн 25 телевизээр, FM-107.5, "Comfort live radio FM-89.1" зэрэг 12 богино долгионы радиогоор мэдээлэл, сэрэмжлүүлэг хүргэж.

Гудамж талбай, олон нийтийн газруудад гэмт хэрэг, зөрчил гарч болзошгүй эмзэг цэгийн байршлын судалгааг гаргаж, давхардсан тоогоор 550 цагдаагийн алба хаагчийг хуваарьт оруулан явган эргүүлийн 125, машинт эргүүлийн 44 чиглэлд ажиллуулж, 5750 зөрчлийг илрүүлж /телекамерын хяналтаар 2/, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтаар 5700 иргэнд 250.750.000 төгрөгийн торгууль оногдуулж, 5660 эцэг эх, асран хамгаалагчдыг эргүүл /School police/-ийн сургуулийн бүс орчинд үүрэг гүйцэтгүүлсэн.

Мөн арга хэмжээний хүрээнд гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлээр 24 албан мэдэгдлийг, 1500 аж ахуй нэгж байгууллагад хүргүүлж, мэдэгдлийн хариуг хугацаанд нь авч, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр мэдээ, мэдээлэл цуглуулан бага насны хүүхэд бэлгийн хүчирхийллийн хохирогч болохоос урьдчилан сэргийлж, 15 хүүхдийн аюулгүй байдлыг хангаж “Түр хамгаалах” байранд хүлээлгэн өгч, хариу үйлчилгээг шуурхай авч ажилласан.

Тээврийн хэрэгслийн жолооч нар хөдөлгөөний үед гар утас болон түүнтэй ижил төстэй төхөөрөмж хэрэглэх зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдөр 1/5378 дугаартай албан бичгээр Цагдаагийн байгууллагад ирүүлсэн үүрэг, чиглэлийн дагуу улсын хэмжээнд “Жолооны ард утсаа больё” арга хэмжээг “Зөв дадал, энгийн соёл” уриатайгаар 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрөөс 11 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэлх 14 хоногийн хугацаанд зохион байгуулж, жолооны ард гар утас ашиглахаас татгалзах дадлыг бий болгох зорилго бүхий зурагт хуудас 16, видео контент 10, нийтлэл 1, телевизийн мэдээ 5, фм радио 5, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас дэмжих зурагт хуудас 30 ширхгийг тус тус мэргэжлийн байгууллагуудтай хамтран бэлтгэж, хэвлэл, мэдээлэл олон нийтийн цахим сүлжээнд байршуулж иргэд, олон нийтэд хүргэсэн.

Контент, мэдээллүүдийг цагдаагийн байгууллагын цахим хуудсаар түгээх ажлыг зохион байгуулж, нийт 20.918 хүнд таалагдаж, 1036 хүн сэтгэгдэл үлдээж, 22.958 хүн бусадтай хуваалцаж, давхардсан тоогоор 2.039.432 хүнд хүргэсэн байна.

Улсын хэмжээнд 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн байдлаар Зөрчлийн тухай хуулийн 14.7.22 дахь хэсгийг зөрчиж замын хөдөлгөөнд оролцох үедээ гар утас ашигласан 32.402 зөрчлийг цагдаагийн байгууллагаас илрүүлж, торгуулийн шийтгэл оногдуулж ажилласан. Үүнээс арга хэмжээг зохион байгуулсан 14 хоногийн хугацаанд гудамж замд тавих хяналт шалгалт болон замын хөдөлгөөний хяналтын камераар нийт 5966 зөрчил илрүүлж хуулийн хүрээнд арга хэмжээ тооцож ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зөрчил илрүүлэлт 5298 нэгжээр буюу 8.9 дахин өссөн байна.

Мөн Нийслэлийн засаг даргын 2022 оны А/1369 дугаартай захирамжаар 800,0 сая төгрөгийг шийдвэрлүүлж Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Удирдлагын төвийн серверийн өрөөний техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, автобусны буудлын хяналтын цэг байгуулах (103 буудал), автобусны хяналтын цэгийг тус төвтэй холбох сүлжээ, дэд бүтцийн ажлын гэрээ байгуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулж, НЗДТГ-ын даргад хүргүүлснээр “Бодь Электроникс” ХХК-тай хамтран ажиллаж байна.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЭЛТЭС